



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠢᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/180

Алгай хот


**Гамшгийн сангаас хөрөнгө
зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 161 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2023 оны 08 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах команд штабын сургуульд шаардагдах нэмэлт зардал, Жаргалан сумын Завхан гол багийн 38 өрхийг нүүлгэн шилжүүлсэн зардал, аймгийн Онцгой комиссын гишүүд Тайшир, Жаргалан сумд ажилласан шатахууны зардал, Онцгой байдлын газрын эрэн хайх, аврах бүлэг гамшгийн дуудлагаар ажилласан шатахууны зардал болох нийт 16,192,650 (арван зургаан сая нэг зуун ерэн хоёр мянга зургаан зуун тавь) төгрөгийг гамшгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай..

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 20... оны ...
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО



№	Зардлын нэр	Зардлын хэмжээ (төгрөг)
1	Гамшгаас хамгаалах команд штабын сургуульд шаардагдах нэмэлт зардал	9,820,000
2	Жаргалан сумын Завхан гол багийн 38 өрхийг нүүлгэн шилжүүлсэн зардал	4,085,000
3	Аймгийн Онцгой комиссын гишүүд Тайшир, Жаргалан сумд ажилласан шатахууны зардал	1,043,650
4	Онцгой байдлын газрын эрэн хайх, аврах бүлэг гамшгийн дуудлагаар ажилласан шатахууны зардал	1,244,000
	Нийт	16,192,650

__оОо__